

САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх  
үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг шинэчлэн  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.29, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээг нэгдүгээр, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны зардлын жишгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг 2026 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат) нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/247 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Ж.ЧИНБҮРЭН

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Төлбөрийн хэмжээ (төг)
1.	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	3,000,000
2.	Өрхийн эрүүл мэндийн төв	5,000,000
3.	Сувилал, Сувилахуйн төв, Сэргээн засах төв, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв (50 хүртэл ортой)	5,000,000
4.	Сувилал, Сувилахуйн төв, Сэргээн засах төв, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв (51-ээс дээш ортой)	6,000,000
5.	Оргүй клиник	5,000,000
6.	Ортой клиник (30 хүртэл ортой)	7,000,000
7.	Ортой клиник (31-ээс дээш ортой)	8,000,000
8.	Амаржих газар	8,000,000
9.	Нэгдсэн эмнэлэг (100 хүртэл ортой)	8,000,000
10.	Нэгдсэн эмнэлэг (101-ээс дээш ортой)	10,000,000
11.	Түргэн тусламжийн төв	8,000,000
12.	Тусгай эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (50 хүртэл ортой)	7,000,000
13.	Тусгай эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (51-100 ортой)	8,000,000
14.	Тусгай эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (101-300 ортой)	9,000,000
15.	Тусгай эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (301-ээс дээш ортой)	10,000,000
16.	Лаборатори	8,000,000
17.	Монгол Уламжлалт анагаах ухааны эмнэлэг	5,000,000
18.	Магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээ	2,000,000

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЖИШИГ

№	Үйл ажиллагааны нэр	Хэмжих нэгж	Удаа	Зардлын хэмжээ (төг)
Нэг. Магадлан итгэмжлэх зөвлөлийн хурлын зардал				
1.1	Гишүүдийн зардал	Төгрөг	Хурлын тоо, цаг	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно.
Хоёр. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой зардал				
2.1	Хурлын бичиг хэрэг, харилцаа холбоо, цай	Төгрөг	Хурлын тоо	200,000
Гурав. Эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийх шинжээчийн ажлын хөлс				
3.1	Багийн ахлагчийн ажлын хөлс	Төгрөг	Эрүүл мэндийн байгууллагад ажилласан цаг	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно.
	Багийн гишүүний ажлын хөлс	Төгрөг		
3.2	Шинжээчийн гэнэтийн ослын даатгал	Төгрөг	Батлагдсан төсөвөөр	
Дөрөв. Магадлан итгэмжлэлийн бусад үйл ажиллагаа				
4.1	Багшийн зардал: Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, шинжээчдийг чадавхжуулах сургалт	Цаг, төгрөг	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно.	
4.2	Үйл ажиллагааны зардал: Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, шинжээчдийг чадавхжуулах сургалт	Тоо, төгрөг	Сургалтын батлагдсан төсөвөөр	
4.3	Олон улсын чанарын нийгэмлэгийн гишүүнчлэлийн хураамж	Төгрөг	Тухайн жилийн тарифаар	
4.4	Магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээ хийх ажлын хөлс	Төгрөг	Эрүүл мэндийн байгууллагын тоо, цаг	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон нэг цагийн

			хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно.
Тав. Орон нутагт ажиллах			
5.1	Томилолтоор ажиллах	Хоног	Сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан албан томилолтын зардлын тариф батлах тухай тушаалаар
5.2	Тээврийн зардал	2 талдаа	Тухайн жилийн зорчигч тээврийн батлагдсан тарифаар

---000---